



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 426

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1. Эрчим хүчний системд 2018 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр үүссэн аваар ослын нэгдсэн дүгнэлтээр “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК нь “Дулааны 4 дүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн ТГ-7-д үзлэг үйлчилгээ, цэвэрлэгээ хийх захиалгын дагуу олгосон зөвшөөрлийн гүйцэтгэлд хяналт тавиагүй, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн алдаатай боловсруулсан сэлгэн залгалтын програмыг бүрэн хянаагүй, сэлгэн залгалтын програмын болон сэлгэн залгалт хийхийн өмнө “Дулааны 4 дүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн ээлжийн диспетчертэй мэдээлэл солилцоогүй зэрэг шуурхай ажиллагаа явуулах хүмүүсийн харьцааны зааврын 4.1, 4.2, 4.4, 4.8, 4.10 дахь заалтыг тус тус зөрчсөнийг тогтоосон тул контрактын 5.2.3, 5.3.4, 5.3.11 дэх заалтын дагуу “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Балдоржийг 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг холбогдох хууль тогтоомжийн дагуу цуцлах.

1.2. Авлигатай тэмцэх газрын 2018 оны 05/8113 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2018 оны а/3423 дугаар албан бичгээр ирүүлсэн саналын дагуу “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлаар Г.Балжиннямыг томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



0002293